

ХАЛХЫН БУРХАН ШАШНЫ АНХНЫ ХИЙД ЭРДЭНЭ ЗУУГИЙН ТҮҮХЭНД ХОЛБОГДОХ ГАР БИЧМЭЛ ЭХИЙН ТУХАЙД ӨГҮҮЛЭХ ХЭДЭН ЗҮЙЛ

Товч агуулга: Монголд бурхан шашин дэлгэрсэн түүхийг тэмдэглэсэн түүхийн үнэт зохиол бүтээлүүд бидэнд цөөнгүй уламжлагдаж ирсэний нэг бол Эрдэнэ зуугийн түүхийг өгүүлсэн гар бичмэл эхүүд бөгөөд эдгээрийг судлах, судалгааны эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс энэхүү өгүүлэлд Монгол улсын Төв номын сангийн үнэт ховор номын тасагт хадгалагдаж байгаа «Эрдэнэ зуугийн тухай» нэртэй гар бичмэл эхийн тухай хэдэн зүйл өгүүлэхээр зорьлоо. Тухайлбал гар бичмэл эхийн зохиогдсон он цаг, зохиогч, агуулгын тухай хэдэн зүйл өгүүллээ.

Түлхүүр үгс: Эрдэнэ зуу, Бурхан шашин, Гар бичмэл, Абтай хан.

Khalzangiin Orkhonchimeg
 Mongolian National Defense University
 Ulaanbaatar, Mongolia

SOME ISSUES ON THE ORIGINAL MANUSCRIPT RELATED TO THE HISTORY OF ERDENE ZUU WHICH WAS THE PRIME MONASTERY OF BUDDHISM

Abstract: Original manuscripts about Erdene Zuu's history are one of the precious historical creations about the Buddhism spread over Mongolia. And also requirements to put into research circulation are being held as well. Therefore we aim for saying some issues about a manuscript named «About Erdene Zuu» stored in a rare library of the Central Library of Mongolian this article. For example: there are a few things about the created time, author, and content of the manuscripts.

Key word: Erdene Zuu, Buddhism, Manuscripts, Abtai khan.

Монголд бурхан шашин дэлгэрсэн түүхийг тэмдэглэсэн түүхийн үнэт зохиол бүтээлүүд бидэнд цөөнгүй уламжлагдаж ирсэний нэг бол Эрдэнэ зуугийн түүхийг өгүүлсэн гар бичмэл эхүүд бөгөөд эдгээрийг судлах, судалгааны эргэлтэнд оруулах шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Иймээс энэхүү өгүүлэлд Монгол улсын Төв номын сангийн үнэт ховор номын тасагт хадгалагдаж байгаа «Эрдэнэ зуугийн тухай» нэртэй гар бичмэл эхийн тухай хэдэн зүйл өгүүлэхээр зорьлоо.

Монгол улсын Төв номын санд Эрдэнэ зуугийн түүхэнд холбогдох гурван гар бичмэл эх хадгалагдаж байна. Үүнд:

1. «Эрдэнэ зуу ба Өндөр гэгээний намтар оршвой» [Эрдэнэ зуу ба Өндөр гэгээний намтар оршвой. Гар бичмэл эх] гэсэн нэртэй, 1134-96 дугаартай гар бичмэл эх байна. Энэ гар бичмэл эх шар хавтастай 200 хуудастай, 25x26 харьцаатай. Нүүрний арын хуудсанд улсын төв номын сангийн тамга дараастай «Эрдэнэ зуугийн намтар оршвой» гэсэн бичигтэй.

2. «Эрдэнэ зуу ба Өндөр гэгээний намтар оршвой» [Эрдэнэ зуу ба Өндөр гэгээний намтар оршвой. Гар бичмэл эх] хэмээх нэртэй, нүүрний хуудсанд ягаан бэхээр бичсэн, 1665-96 гэсэн дугаартай, 28x21 гэсэн харьцаа бүхий гар бичмэл эх байна. Уг эх 304 хуудастай, саарал хавтастай, улаан дэвсгэр дээр гарчиг нь мэдэгдэхгүй болсон. Энэ эхийн агуулга нэгдүгээр эхийн агуулгатай бараг адил бөгөөд нэгдэх эхээс хуулан бичсэн бололтой.

3. «Эрдэнэ зуугийн тухай» [Эрдэнэ зуугийн тухай. Гар бичмэл эх] гэсэн нэртэй, 5269-96 гэсэн дугаартай, 46 хуудастай гар бичмэл эх байна. Улаан торгон хавтастай хуудасны нүүрэн дээр шар дэвсгэр дээр «Эрдэнэ зуугийн тухай» хэмээн хар бэхээр бичсэн. Гар бичмэлийн арын хуудсанд мөн «Эрдэнэ зуугийн тухай» гэж бичсэн байх бөгөөд хажуу талд нь улсын номын сан гэсэн ягаан өнгийн тамгатай. Уг эхийн хуудаснууд нь нилээд шарлаж урагдсан байдалтай. 1-5 дугаар хуудсанд хичээнгүй жижиг бичсэн боловч 6 дугаар хуудсанаас таталган бичсэн. 44, 45, 46 дугаар хуудас нь урагдсан байдалтай байна.

Мөн Эрдэнэ зуугийн түүхэнд холбогдох эх хоёр байгаа бөгөөд Үүнд:

1. Эрдэнэ зуугийн бас нэг эх Улаанбаатар хот дахь Ц. Дамдинсүрэнгийн гэр музейд хадгалагдаж байна. Энэ эх «Халх Монголын хан номун Очирой бат Абтай бээр Хятад Арван гуравдугаар Ванлай хааны арван дөрөвдүгээр онд их адистад Эрдэнэ зуу байгуулсан даруй өндөр гэгээн мандаж адистадлан тэтгэмжлэн уламжилсаар дөрөвдүгээр ачит цорж зурагч Лувсанданзан хийгээд ялангуяа долдугаар номч цорж лам үлэмж дэлгэрүүлэн үйлдэж явсан хуучин түүх дэвтэр болой» гэсэн нэртэй. Энэхүү эхийг «История Эрдэни Дзу»

[Цендина, 1999] гэсэн нэрээр А.Д. Цендина тайлбар хийж 1999 онд Москва хотноо хэвлүүлжээ. Энэ эх 55x28.5 харьцаа бүхий хар бэхээр бичсэн 37 хуудастай.

2. Оросын Санкт Петербургийн их сургуулийн номын санд хадгалагдаж буй нэг эх байна. Уг эх «Халх Монголын оронд анх бурхан шажин эх болсон төрөл түүх бас их адистад шүтээн Эрдэнэ зуугийн бүтээх их тууж оршвой» гэсэн нэртэй товч хувилбар юм. Энэхүү хувилбар 32 хуудастай. Тус эхийг XIX зууны сүүлчээр Оросын судлагч А.М. Позднеев Халхад явахдаа олж Санкт Петербурт аваачсан бололтой.

Энэхүү өгүүлэлд «Эрдэнэ зуугийн тухай» нэртэй гар бичмэл эхийн зохиогч зохиогдсон он цаг, доторхи агуулгын тухай хэдэн зүйлийг тодрууллаа.

«Erdeni zuu-yin tuqai» (Эрдэнэ зуугийн тухай) хэмээх нэртэй гар бичмэл эх нь агуулгын хувьд А.Д. Цендиногийн хэвлүүлсэн «Qalq-a mongγol-un qan nomun vačirai batu abtai ber kitad arban γurbduγar vanglai qan-u arban dörbdüger on-du yeke adistad-tu batu erdeni zuu bayiyuluγsan darui öndür gegen mangdaju adistadlan dedgümjilen ulamjilaysaγar dörbdüger ačitu darqan čorji jiruyči lubsang dangjin kiged ilangγui doluduγar nomči čorji blam-a ülemji delgeregölün üileddeju yabuγsan-i qaγučin teüke devter boloi» (Халх Монголын хан номун Очирой бат Абтай бээр Хятад Арван гуравдугаар Ванлай хааны арван дөрөвдүгээр онд их адистад Эрдэнэ зуу байгуулсан даруй өндөр гэгээн мандаж адистадлан тэтгэмжлэн уламжилсаар дөрөвдүгээр ачит цорж зурагч Лувсанданзан хийгээд ялангуяа долдугаар номч цорж лам үлэмж дэлгэрүүлэн үйлдэж явсан хуучин түүх дэвтэр болой) гэсэн нэртэй эх, мөн Петербургийн их сургуулийн номын санд буй гар бичмэл эхтэй адил байгаа бөгөөд хуудасны тоо нь адилгүй байна.

«Эрдэнэ зуугийн тухай» нэртэй гар бичмэл эхийн хэдий үед зохиогдсон нь тодорхойгүй боловч Ц. Дамдинсүрэнгийн гэр музейд хадгалагдаж буй гар бичмэл эхийн өмнөх үгэнд түүний хэдий үед бичсэнийг барагцаалж болох баримт байна. Тухайлбал:

«...abtai ber kitad arban γurbduγar vanglai qan-u arban dörbdüger on-du yeke adistad-tu batu erdeni zuu bayiyuluγsan darui öndür gegen mangdaju adistadlan dedgümjilen ulamjilaysaγar dörbdüger ačitu darqan čorji jiruyči lubsang dangin kiged ilangui doluduγar nomči čorji blam-a ülemji delgeregölün üileddeju yabuγsan» (Абтай хан Эрдэнэ зууг байгуулсан даруй Өндөр гэгээн тэтгэмжлэн Дөрөвдүгээр ачит цорж зурагч Лувсанданзан болон ялангуяа долдугаар номч цорж лам үлэмж дэлгэрүүлэн үйлдэж явсан хуучин түүх) [Цендина, 1999, т. 180] гэснээс үзэхэд Өндөр гэгээний ивээлээр Эрдэнэ зуугийн дөрөвдүгээр цорж лам Лувсанданзан болон долдугаар цорж лам Лувсандагвадаржаа нар дэлгэрүүлэн зохиосон тул Дөрөвдүгээр цоржийн амьдарч байсан үе болох XVII-р зууны дундаас XVIII зууны эхэн болон Долдугаар цоржийн амьдарч байсан XVIII зууны эхэн үеэс XIX зууны эх хүртлэх буюу XVII зууны дунд үеэс XIX зууны эх хүртлэх үеүүдэд үе улиран бичигджээ гэж үзэж болохоор байна.

«Эрдэнэ зуугийн тухай» хэмээх гар бичмэл эхийг хэн зохиосон нь тодорхойгүй боловч гар бичмэл эхэд бичсэнчлэн «dörbdüger ačitu darqan čorji jiruyči lubsang dangin kiged ilangγui doluduγar nomči čorji blam-a ülemji delgeregölün üileddeju yabuγsan» (дөрөвдүгээр ачит дархан цорж зурагч Лувсанданзан хийгээд ялангуяа долдугаар номч цорж лам үлэмж дэлгэрүүлэн үйлдэж явсан) [Цендина, 1999, т. 180] гэснээс харахад дөрөвдүгээр дархан цорж зурхайч Лувсанданзан, тавдугаар гаанжуур өвгөн номч цорж Лувсанжалцан, зургадугаар дархан цорж Лувсанцэдэн, долдугаар хувилгаан цорж Дагвадаржаа нарын үед үе улиран дэлгэрүүлэн зохиожээ гэж үзэж болох юм. Өөрөөр хэлбэл Эрдэнэ зуугийн дөрөвдүгээр цорж Лувсанданзан эхлэн зохиож түүний дараагийн цорж нарын үед үргэлжлүүлэн долдугаар цорж Лувсандагвадаржаа дуусгасан бололтой.

«Эрдэнэ зуугийн тухай» хэмээх гар бичмэл эхийн Товч агуулгаийг авч үзье. Тус эхийн агуулга нь эхлэхдээ «enekü yeke adis-tad-un erdeni juu-yi bayiyuluγsan-i ögegüleküi tür erte čaγ u... жүг-үн mongγol orun-tur šajin delgeregsen yosun ba mongγol biden-ü ene orun tu šajin delgeregsen yosun kiged qalq-a erdeni juu kemekü süm-e sitügen ni bayiyulju šajin delgeregsen yosun-nuyud yi öčüken tedüi medegsen keriber bičisügei umar-a жүг-үн mongγol-un orun-du šajin delgeregsen yosu kemebesü erte w... amitan-u tusa-dur γuj... tngri-ün erketü qurmust-yin sakiγči badarangqui čaγan tngri-yin köbegün degüs tusadu kemen aldarsiγsa amitan-u tusa-yin tula qümün-ü orun-dur bayuγsan-ača yisün jil boluγsan qoyin-a yisükei bayatur-un köbegün tngri-eče jayaγaysan qüčün-iyer күрдү орčiγулугči činggis qaγan kemen aldarsiγsan aγui yeke qaγan orun olangkin erkedur ejen bolγad mön kü tegüni köbegün ögedei noyan tegün-ü köbegün čing gütüwa-yin üy-e-tü nomun qaγan sasγya-a bandida güngjalčan-yin jirin qoyor següdür degeren jalaqu-yin bičig elči ilegeju erdeni edelel terigüte örgügsen-tü gegen-ber boyda narun lüngden ba amitan-u tus-yi sanaju gegegen bey-e amin ban qaγirlal ügei jiran γurban següdür degere-ben inaγši umar-a tal-a-tur jalarin zama-un olan amitan-i nom-un rašiyau-u-iyar qangan jalaraču» (Энэхүү их адистадын Эрдэнэ зууг байгуулсныг өгүүлэхүйд эрт цаг (умар) зүгийн Монгол оронд шашин дэлгэрсэн ёсон ба Монгол бидний хэн оронд шажин дэлгэрсэн ёсон хийгээд халх Эрдэнэ зуу хэмээх сүм шүтээнийг байгуулж шажин

дэлгэрсэн ёснуудыг өчүүхэн төдий мэдсэний хирээр зүгийн Монголын оронд шажин дэлгэрсэн ёс хэмээвээс эрт амьтны тусад тэнгэрийн эрхэт хурмаст сахигч бадрангүй цагаан тэнгэрийн хөвгүүн дүүс туст хэмээн алдаршсан амьтны тусын тул хүмүүний оронд бууснаас есөн жил болсон хойно Есүхэй баатрын хөвгүүн тэнгэрээс заяасан хүчнээр хүрд орчуулагч Чингис хаан хэмээн алдаршсан агуу их хаан орон олонхийн эрх дур эзэн болгоод мөнхүү түүний хөвгүүн Өгөдэй ноён түүний хөвгүүн Чин Гүдүвагийн үед номон хаан Сахьяа бандид Гунгаажалцангийнт жаран хоёр сүүдэр дээрээ залахын бичиг элч илгээж эрдэнэ эдлэл тэргүүтэн өргөсөнд гэгээн бээр Богд наран лүндэн ба амьтны тусыг санаж гэгээн бие амиа хайрлалгүй жаран гурван сүүдэр дээрээ нааш умар талд залран замын олон амьтныг номын рашаанаар ханган заларч) хэмээн Чингис хаан түүний хөвгүүн Өгөдэй хаанын үед бурхан шашин дэлгэрч байсан тухай бичжээ. Мөн эхэд «qalq-a mongyol biden-ü ene orun-tu sajin delgerigsen-ü yosu anu qubilai sečen qan-ača qorin yutayar üy-e-tur batu möngke dayan qayan boluysan tegüni köbegün jalayir qungtayiji tegünü köbegün üyijeng noyan tegünü köbegün abtai tegünü çay-tu qalq-a-yin arad бүкүн abqu gegекү-yin orun-dur mongyol bolod nigülseküi inü öcükен bey-e-yin ide inü yeke ayumsiγ-tu çereg anu masi olan gerten ba quvaray-un ilayal ügei sajin-u ner-e-yin tedüi çü ugei abatai γalγay yu... bay... kemekü noyan arban tabun nasun-ača mangγus-un qan-u omurqal-yi bulajaqu... abatai-ber γurban erdeni-yin ner-e-i sonusuyad sedgel masida bayasaçu burqan-u sajin-dur ülemjide süsülüsün udal ügei kitad-un qayan-i arban dörbedüger üy-e wan lii qang-i tabuduyar on-u γal üker jil-dü qamuy-i ayiladduyçi sonüjamçu dalai blam-a tumed-ün altan qayan jalaju mongyol-un orun küke qota kemekü γajar-tu bayiqu-yin üy-e-dü mön kü abatai-ber jolγura odduyad mörgüküi-dür waçirbani-yin qubilyan mön basa degüü köngdülen sayin noyan-i qonsimbodisadu-yin qubilyan mön kemen todurqai jarliy bolyad» (Халх Монгол бидний энэ оронд шажин дэлгэрсэний ёс нь Хубилай сэцэн хаанаас хорингуравдугаар үед Батмөнх даян хаан болсон түүний хөвгүүн Жалайр хунтайж түүний хөвгүүн Үйзэн ноён түүний хөвгүүн Абтай түүний цагт халхын ард бүхэн авах гээхийн оронд монгол болоод нигүүлсэхүй нь өчүүхэн биеийн эд нь их аймшигт цэрэг нь маш олон гэртэн ба хуврагийн ялгал үгүй шажины нэрийн төдий ч үгүй Абтай галзуу... хэмээх ноён арван таван наснаас мангасын ханы оморхлыг булааж... Абтай бээр гурван эрдэнийн нэрийг сонсоод сэтгэл машид баясаж бурханы шажинд үлэмжид сүсэлсэн удалгүй Хятадын хааны арван дөрөвдүгээр үе Ванли ханыг тавдугаар оны гал үхэр жилд хамгийг айлдагч Сономжамц Далай лам Түмэдийн Алтан хаан залж Монголын орон Хөх хот хэмээх газарт байхын үед мөнхүү Абтай бээр золгоор одоод мөргөхөд Очирваанын хувилгаан мөн бас дүү Хөндлөн сайн ноёныг Хоншимбодсадын хувилгаан мөн хэмээн тодорхой зарлиг болгоод) хэмээн Халхын Абтай ханыг бурхан шашинд хэрхэн даган орсон түүхийн үнэ цэнэтэй мэдээг бичсэн байна.

Энэ бүхнийг эцэст нь дүгнэхэд «Абтай хан Эрдэнэ зууг байгуулсан даруй Өндөр гэгээн тэтгэмжлэн Дөрөвдүгээр ачит цорж зурагч Лувсанданзан болон ялангуяа долдугаар номч цорж лам үлэмж дэлгэрүүлэн үйлдэж явсан хуучин түүх» гэснээс үзэхэд Өндөр гэгээний ивээлээр Эрдэнэ зуугийн дөрөвдүгээр цорж лам Лувсанданзан болон долдугаар цорж лам Лувсандагвадаржаа нар дэлгэрүүлэн зохиосон тул Дөрөвдүгээр цоржийн амьдарч байсан үе болох XVII-р зууны дундаас XVIII зууны эхэн болон Долдугаар цоржийн амьдарч байсан XVIII зууны эхэн үеэс XIX зууны эх хүртлэх буюу XVII зууны дунд үеэс XIX зууны эх хүртлэх үеүүдэд үе улиран бичигджээ гэж үзэж болохоор байна. Мөн «Эрдэнэ зуугийн тухай» хэмээх гар бичмэл эхийг хэн зохиосон нь тодорхойгүй боловч гар бичмэл эхэд бичсэнчлэн дөрөвдүгээр цоржоос долдугаар цорж хүртэл дэлгэрүүлэн зохиосон гэснээс харахад дөрөвдүгээр дархан цорж зурхайч Лувсанданзан, тавдугаар гаанжуур өвгөн номч цорж Лувсанжалцан, зургадугаар дархан цорж Лувсанцэдэн, долдугаар хувилгаан цорж Дагвадаржаа нарын үед үе улиран дэлгэрүүлэн зохиожээ гэж үзэж болох юм.

Ном зүй

Бира Ш. Монгольская историография (XIII-XIV вв.). М.: Наука, Главная редакция восточной литературы, 1978. 319 с.

Пэрлээ Х. Монголын хувьсгалын өмнөх үеийн түүх бичлэгийн асуудалд. Улаанбаатар, 1958. 45 т.

Цендина А.Д. История Эрдэни-дзу. Факсимиле рукописи. Перевод с монгольского, введение, комментарий и приложения А.Д. Цендиной // Памятники письменности Востока. М.: Изд. фирма «Восточная литература РАН», 1999. 255 с.

Эрдэнэ зуу ба өндөр гэгээний намтар оршвой. Монгол улс. ҮНС. Гар бичмэл эх.

Эрдэнэ зуугийн тухай. Монгол улс. ҮНС. Гар бичмэл эх.